

ТЭМДЭГЛЭЛТ ОЙ

КОММУНИСТ—ИНТЕРНАЦИОНАЛЧ ВАН МИН

Хятадын Коммунист Нам, олон улсын коммунист хөдөлгөөний гарамгай зүтгэлтэн, коммунист-интернационалч Ван Мин эдүгээгээс 80 жилийн тэртээ буюу 1904 оны 5-р сарын 23-нд Хятадын Аньхуэй мужийн Люань хошуунд багшийн гэр бүлд мэндэлжээ. Уг нэр нь Чэнь Шаоюй гэх боловч хувьсгалт тэмцэлд оролцохдоо нууцлан хэрэглэж байсан Ван Мин гэдэг нэрээр олноо алдаршсан билээ.

Эцгийнхээ зөвлөснөөр сургууль, номын мөр хөөж, эрдэм номд шимтэн явсан идэр залуухан Ван Мин 1924 онд ХКЗЭ-ийн гишүүнд элсэж, оюутан хувьсгалт хөдөлгөөнд идэвхтэй оролцох болж, улмаар 1925 онд 21 насандаа ХКН-ын эгнээнд элсжээ.

Хятадын ард түмний үндэсний болон нийгмийн эрх чөлөөний төлөө амьдрал тэмцлээ зориулах нэгэн үзүүрт сэтгэлд хөтлөгдөн явсан Ван Мин 1925 оны эцсээр дэлхийн ууган социалист орон—ЗХУ-д ирж Сунь Ятсений нэрэмжит хятадын хөдөлмөрчдийн коммунист их сургуульд суралцжээ. Зөвлөлтийн ялгуусан их туршлагаас бүх талаар суралцахгүйгээр Хятадын хувьсгал амжилт олно гэж сэтгэшгүй хэрэг хэмээн хожим Ван Мин бичсэн нь Лениний эх оронд очиж суралцсан зорилгоо тодорхойлсон хэрэг байлаа.

ХКН-ын туулж өнгөрүүлсэн түүхэн замналыг эргэн үзвэл марксист-ленинист интернационалч чиглэл, жижиг хөрөнгөтний үндсэрхэх урсгалын хоорондын тэмцэл ХКН-ын хөгжил, түүх, улс төрийн амьдралын гол онцлог шинж болж ирснийг харж болно. Хятадын коммунист намын доторхи интернационалч хүчний гол төлөөлөгч Ван Мин 1929-1930 онд ХКН-д чухамдаа удирдах үүрэг гүйцэтгэж байсан Ли Лисаны жижиг хөрөнгөтний үндсэрхэг балмад бодлогыг эрс шийдвэртэй эсэргүүцсэн юм. Ли Лисань болон намын эрхэнд гарах гэж санаархаж байсан Мао Зэдун нар Коминтернийн үнэлэлт, зөвлөлгөөнийг үл хайхран тухайн үеийн хятадын нөхцөл байдлыг харгалзалгүй хувьсгалыг түргэвчлэн, газар сайгүй бослого, ажил хаялт зохион байгуулах хэрэгтэй гэж үзэж байв. Тэр «хятадын хувьсгалыг ялалтанд хүргэхийн тулд» ЗХУ ба империалист гүрнүүдийн хооронд дэлхийн дайн өдөөх, дэлхийн хувьсгалыг зохиомлоор түргэтгэх гэж санаархаж байв.

Хятад дахь хувьсгалт хөдөлгөөн, ХКН-д хүнд ноцтой уршиг учруулж болох Ли Лисаны энэ чиг шугамыг Ван Мин эрс шүүмжилж байлаа. Гэвч Ли Лисаны талынхан энэ шүүмжлэлийг үл хайхран, Ван Миний талынхныг «барууныхан» «бүлэглэл гаргагчид» гэж буруутган зэмлэж, тэдэнд сахилга батын хатуу шийтгэл оногдуулж байжээ. Гэвч Ван Мин үзэл бодлынхоо үнэн зөвд бат итгэн, эрс хатуу тэмцсээр байлаа. Ли Лисаныхантай хийсэн тэмцэлд Ван Миний эрэлхэг зориг, дайчин шийдмэг чанар хурц илэрсэн төдийгүй тэрээр онол улс төрийн хувьд бүрэн боловсорсоноо харуулсан юм. ХКН-д ийм эгзэгтэй хэцүү үе тулгараад байхад Ван Мин өөрийн зарчимч байр сууриа хатуу баримталсны үрээр ХКН-ын үлэмж нэр хүндтэй зүтгэлтний нэг болж тодорсон билээ.

Намын өмнө байгуулсан гавьяаг нь үнэлж, Ван Минийг 1931 оны 1-р сард хуралдсан ХКН-ын Төв Хорооны VI дахь удаагийн IV бүгд хурлаас ХКН-ын Төв Хорооны гишүүн, Улс төрийн Товчооны гишүүн, Төв Хорооны нарийн бичгийн даргаар сонгосон байна.

Хятадын коммунистуудын анхан үеийн төлөөлөгчийн нэг Ван Миний нэр 1930—1940-өөд онд дэлхийн коммунист хөдөлгөөний зүтгэлтнүүдийн дунд ихээхэн нэр хүндтэй байлаа. 1931 оны 11-р сараас эхлэн Коминтерн дэх ХКН-ын төлөөлөгчөөр бүтэн 6 жил үр бүтээлтэй ажилласан юм. 1932—1943 онд Коминтернийн гүйцэтгэх хорооны тэргүүлэгч гишүүн, тус хорооны нарийн бичгийн дарга нарын газрын орлогч гишүүнээр сонгогдож байхдаа Георгий Димитров, Пальмиро Тольятти, Вильгельм Пик болон дэлхийн коммунист ажилчны хөдөлгөөний бусад нэрт зүтгэлтнүүдтэй хамт ажиллаж байв. Ван Мин Коминтерний үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, пролетарийн интернационализмын сургуулийг туулсан нь марксизм-ленинизмын үзэл суртлын зэвсгээр зэвсэглэсэн, намын ажлын дайчин туршлага хуримтлуусан, тууштай марксист- ленинист улс төрийн удирдагч болон хатуужихад чухал шат болжээ.

Ван Мин Коминтернд ажиллаж байхдаа японыг эсэргүүцсэн үндэсний нэгдмэл фронт байгуулж, бэхжүүлэхийн төлөө идэвхтэй ажиллаж байсан нь тухайн үеийн хятадын нөхцөл байдлаас зайлшгүй урган гарсан шаардлага байлаа. 1937 оны 12-р сард хуралдсан ХКН-ын ТХ-ны Улс Төрийн Товчооны өргөтгөсөн хуралдаан, 1938 оны 4-р сард баталсан Төв Хорооны сэдэв болон намын бусад баримт бичигт Коминтерн дахь Ван Мин олон талт үйл ажиллагааг өндөр үнэлсэн юм.

Эх орондоо эргэж ирсний дараа Ван Мин ХКН-ын удирдлагад ажиллаж, ХКН-ын ТХ-ны Төв Хятадын товчоог удирдаж байв. Энэ товчооны үйл ажиллагааны эсрэг Мао Зэдуны Яньань дахь бүлэглэлийн «онцгой» чиг шугам сөргөлдөж байна.

Нам, ард түмэнд Ван Мин өндөр нэр хүндтэйг харгалзан, Мао Зэдун арга буюу түүнийг талаар татах гэж оролдож байсан боловч Ван Мин марксист-ленинист зарчимт байр сууриндаа бат зогсож байв. Мао Зэдун Коминтерн, коммунист интернационалчдын эсрэг тэмцэхдээ Ван Минийг гол саад гэж үзэж байлаа. Мао Зэдун ХКН-ын удирдлагыг булаан авч, «хятадчилсан марксизм» гэгчээ намд тулган хүлээлгэх гэж оролдож байсан үедээ Ван Миний эсрэг элдэв явууллага хийж байв. Бүр 1941 онд түүнд хор өгч хөнөөх гэсэн жигшүүрт оролдлого хийж байсан нь Ван Миний эрүүл мэндэд ноцтойгоор нөлөөлсөн юм. Мао Зэдун 1941—1945 онд ХКН-ын доторхи коммунист интернационалч хүчнийг харгислан дарах, коммунистуудын дунд «сэтгэл санааны цэвэрлэгээ» хийхийг гол зорилго болгосон «Ажлын арга барилыг засах» гэгч кампанийн үед Ван Мин зэрэг ХКН-ын нэрт зүтгэлтнүүдийн үйл ажиллагаа болоод Коминтерний түүхэн гавьяаг үгүйсгэх гэж оролдсон юм.

Энэ хөдөлгөөний үед ХКН-ын доторхи интернационалч хүчин суларч, арга буюу ухралтанд орсон боловч маогийнхан үзэл бодлоо баттай тогтоож чадаагүй юм. 1945 онд хуралдсан ХКН-ын VII их хурал, 1956 онд хуралдсан VIII их хурлаар Ван Мин ХКН-ын Төв Хорооны гишүүнээр сонгогдсон байна.

БНХАУ байгуулагдсаны дараа Ван Мин Ардын Төв Засгийн газрын хууль тогтоомж боловсруулах комиссын ажлыг удирдаж байв. Тууштай интернационалч коммунист Ван Мин ХКН, ЗХУКН ба ах дүү бусад коммунист намуудтай нягт хамтын ажиллагаатай байх, ЗХУКН-ын хувьсгалт тэмцлийн ба ЗХУ дахь социалист байгуулалтын турш-

лагаас суралцах, Хятад-Зөвлөлтийн ард түмний найрамдлын төлөө ямагт шийдвэртэй тэмцэж байв.

Ван Мин 1956 онд ХКН-ын Төв Хорооны зөвшөөрснөөр ЗХУ-д эмчлүүлэхээр очиж, амьдралын сүүлчийн өдөр хүртэл тэнд байсан юм.

Ван Мин амьдралынхаа бүхий л үеийн турш маоизмтай ил шууд тэмцэл явуулж, Мао Зэдуны явуулж байсан удаа дараагийн шуугиант кампани, тухайлбал «гурван улаан тугийн бодлого», «соёлын хувьсгал» гэгч нь Хятадын ард түмэнд ямар их гай зовлон, үхэл хагацал, үгүйрэл хоосрол авчирсныг илчилж, ард түмний эсрэг социализмын эсрэг чиглэсэн ийм бодлого нь империализм, дэлхийн хамгийн харгис хүчинтэй холбоо байгуулахад хүргэнэ гэж урьдчилан хэлж байжээ. Ван Мин практик үйл ажиллагаа, онолын бүтээл, олон арван нийтлэл өгүүллээрээ маоизмын эсрэг тэмцэлд жинтэй хувь нэмэр оруулжээ. Тиймээс ч тэр эх орондоо ч, дэлхийн дэвшилт олон нийтэд ч ихээхэн нэр хүндтэй юм.

Ван Мин үзэл суртал-онолын баялаг өв үлдээж, өөрийн зохиол бүтээлүүдэд ХКН дахь интернационал байр суурийг хамгаалан, хятад дахь троцкизм, оппортунист хэлбэрийн янз бүрийн урсгалын эсрэг эвлэршгүй тэмцэл явуулж байв. Тэрээр «Хоёр шугамын тэмцэл», «Хятад дахь хэрэг явдлын тухай», «Ленин, Ленинизм, Хятадын хувьсгал», «ХКН-ын хагас зуун жил ба Мао Зэдуны урвагч үйл ажиллагаа» зэрэг зохиолдоо троцкизм, маоизмын нийгмийн үндэс, оппортунист мөн чанар, ХКН дахь жижиг хөрөнгөтний үндсэрхэг бүлгийн их гүрний дээрэнгүй үзлийн хор уршгийг илчлэн няцааж, эрс шүүмжилж байв.

Ван Миний зохиол бүтээлүүд нь ХКН дахь хоёр шугамын тэмцлийн үнэн бодит дүр зургийг бодитойгоор ойлгох, маогийнхан ХКН-ын түүхийг хэрхэн гуйвуулж буйг баримтад тулгуурлан танин мэдэх бололцоог олгож байгаагаараа чухал ач холбогдолтой юм. Ван Мин онолч, нийтлэлч төдийгүй авьяаслаг яруу найрагч байлаа. Яруу найраг бол Ван Миний хувьд Хятадын ард түмний болон, хоёрдогч эх орон нь болсон ЗХУ-ын дайснуудтай, хамгийн аюулт дайсан болох маоизмтай тэмцэхэд нь үнэнийг уран сайхны сэтгэлгээгээр нээн харуулах өвөрмөц нэгэн зэвсэг нь болж байлаа.

Ван Миний олон бүтээл ЗХУ болон дэлхийн бусад олон оронд хэвлэгдэн гарч байлаа. ХКН-ын өнөөгийн түүх судлалд «Зүүний адал балмад бодлоготон», «Зүүнтэн» гэж нэрлэгдсээр байгаа хүний нэг бол чухам хятадын ард түмний үнэнч хүү, тууштай интернационалч Ван Мин юм. Түүхийг гуйвуулах ийм оролдлого явуургүй болохыг түүх өөрөө нотолж байна.

Ван Миний амьдрал, үйл ажиллагаа бол марксизм-ленинизм, пролетарийн интернационализмд үнэнч байхын тод жишээ, олон улсын коммунист хөдөлгөөний эв нэгдлийн төлөө, хятадын социалист хөгжлийн төлөө зарчимч тэмцэл, Хятадын ард түмний гэрэлт маргаашийн төлөө амь бие хайргүй зүтгэхийн үлгэр дууриал болж байна. Чухам ийм ч учраас дэлхийн дэвшилт хүн төрөлхтөн, коммунист-интернационалч, Хятадын ба олон улсын коммунист хөдөлгөөний нэрт зүтгэлтэн Ван Миний 80 жилийн ойг ёслон тэмдэглэж, Хятадын ард түмний үнэнч хүүд гүн хүндэтгэлээ илэрхийлж байгаа юм.

Л. Бэгзжав